



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/140/СТА-ТШЗ

Баянхонгор 2020 он	Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usuhuu83@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13

1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Г.БАЙГАЛМАА ТАНАА

2020.08.18 № 1/122

танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020070

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.Аудитын тайлан

2.1. Оршил

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Г.Байгалмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 14-нөөс 2020 оны 02 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 108 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэн нотолгоонд тулгуурласан нийтийн эрүүл мэндийн

болон эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөжүүлснээр хүн амд ээлтэй, тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг үзүүлэхэд оршино".

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Инээмсэглэл эерэг харилцаа, уриан дор үйлчлүүлэгч бүрд эерэг сэтгэл ханамжийг тэгш хүргэж үйлчлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах
- Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.
- Төсвийн тухай хууль
 - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
 - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
 - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
 - Шилэн дансны тухай хууль
 - Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
 - Эрүүл мэндийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 35 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 406343.5 мянган төгрөгөөс тооцон 8126.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 8126.9 мянган төгрөгөөр тооцсон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58939.7 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	/мянган төгрөг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	45,330,435.40	41,592,945.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	00.00	296,000.00
34	УРЬДЧИЛГАА	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	45,330,435.40	41,296,945.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	157,823,960.35	150,728,714.91
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	157,823,960.35	150,728,714.91
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	203,154,395.75	192,321,660.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	203,154,395.75	192,321,660.31
51	Засгийн газрын хувь оролцоо	203,154,395.75	192,321,660.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	203,154,395.75	192,321,660.31

Бараа материалын дансны үлдэгдэл 4033.5 мянган төгрөгөөр буурсан нь түлш шатахууны данс дахь 5183.1 мянган төгрөгийн нүүрсний үлдэгдлийн тайлант онд зарцуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 24517,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 10360.0 мянга, үнэ төлбөргүй 18648.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 7 дугаар тогтоолоор 4490.9 мянган төгрөгийн хөрөнгө акталж тайлант онд 36104.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал нэмж байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 192321.7 мянган төгрөг болж 10832.7 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүн 10832.7 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 71602 кодтой нэг хөтөлбөрт зориулан 371905.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 332647.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 21501.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 17756.2 мянган төгрөгийн Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд улсын төсвөөс 332647.1 мянга, орон нутгийн төсвөөс 21501.7 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 17701.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулан авч үзэхэд тайлант онд хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал хийх зардал төлөвлөснөөс 533.1 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 371416.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь улсын төсвөөс 332647.1 мянга, орон нутгийн төсвөөс 21501.7 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 17701.8 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зарцуулж 433.8 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансанд 117.4 мянган төгрөгийн ийлдэс тээврийн орлого орсныг зориулалтын дагуу зарцуулсан байна..

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 35 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 26 эрсдэл тодорхойлж нийт 22 горим сорил хэрэгжүүлээ.

Аудитаар нийт 3029.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1799.1 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 1230.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 3029.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1799.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1.1. Хүнсний зардлын төсвөөс хэмнэгдсэн зардлыг шилжүүлэн тайлант хугацааны эцэст төвлөрүүлээгүй их хэмжээний худалдан авалт хийж 1799.1 мянган төгрөгийн хүнс илүү нөөцөлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Аудитаар илэрсэн 1230.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 133 мэдээллийг хугацаанд нь, 31 мэдээлэлд байршуулснаас хойш дахин засвар хийснээс хугацаа хоцроосон төлөвт орж, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	31	5	
5	Тухай бүр	8	96	70	26	
	Нийт	27	151	118	31	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

- 1.1. **Илрүүлэлт:** Биет бус хөрөнгөд бүртгэлтэй 650.0 мянган төгрөгийн программ хангамжаас гадна 200.0 мянган төгрөгийн үнэтэй архивын программ нь ашиглалтгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.5 дахь "Тооллогын комисс, түүний үүргийг "эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон ... бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих" гэсэн заалтай нийцэхгүй байна.
- 1.2. **Эрсдэл:** Ашиглалтгүй биет бус хөрөнгө санхүүгийн тайланд бүртгэлтэй байх
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Төрийн архивын программыг цаашид ашиглах боломжтой эсэхийг тодруулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Цаашид алдааг давтан гаргахгүй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

- 2.1 **Илрүүлэлт:** Цалин, НДШ-ийн зардлыг анхан шатны баримтаас түүвэрлэн давтан тооцоолоход 1030.8 мянган төгрөгийн цалингийн санг нийгмийн даатгалын хэлтэст мэдээлээгүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.
- 2.2. **Эрсдэл:** Цалингийн санг илүү дутуу мэдээлж өр авлага үүсгэх
- 2.3 **Өгсөн зөвлөмж:** Цалингийн санг тухай бүр нь үнэн зөв мэдээлж, өмнөх оны дутуу мэдээлсэн 1030,0 мянган төгрөгийн нөхөн мэдээлж цаашид Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	45,330,435.40	41,592,945.40
33	АВЛАГА	00.00	296,000.00
335	Бусад авлага	00.00	296,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	296,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	45,330,435.40	41,296,945.40
351	Түүхий эд материал	8,621,635.00	8,430,935.00
35110	Тусгай зориулалттай материал	8,621,635.00	8,430,935.00
354	Хангамжийн материал	36,708,800.40	32,866,010.40
35410	Бичиг хэргийн материал	1,047,500.00	676,480.00
35420	Аж ахуйн материал	28,326,990.00	29,790,740.00
35440	Түлш, шатах тослох материал	5,183,100.00	00.00
35460	Хүнсний материал	2,151,210.40	2,398,790.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	157,823,960.35	150,728,714.91
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	157,823,960.35	150,728,714.91
392	Биет хөрөнгө	146,209,960.35	139,114,714.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	89,032,377.00	89,032,377.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-15,488,521.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,640,000.00	34,640,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9,221,111.13	-15,547,777.77
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	110,520,424.27	127,308,379.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-79,981,925.55	-88,913,073.55
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,294,086.50	17,974,086.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,247,890.74	-10,114,754.86
39217	Ном	174,000.00	224,000.00
393	Биет бус хөрөнгө	11,614,000.00	11,614,000.00
39301	Програм хангамж	650,000.00	650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-650,000.00	-650,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,614,000.00	11,614,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	203,154,395.75	192,321,660.31
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	203,154,395.75	192,321,660.31
51	Засгийн газрын хувь оролцоо	203,154,395.75	192,321,660.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	175,490,678.27	175,490,678.27
51101	Өмч: - төрийн	175,490,678.27	175,490,678.27
512	Хуримтлагдсан үр дүн	-100,106,858.41	-110,939,593.85
51210	Өмнөх үеийн үр дүн	-100,106,858.41	-100,106,858.41
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-10,832,735.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	127,770,575.89	127,770,575.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	203,154,395.75	192,321,660.31

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	323,131,334.61	395,510,742.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,151,082.61	20,443,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,151,082.61	20,443,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,151,082.61	20,443,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,151,082.61	20,443,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	31,111,852.00	42,419,742.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	283,868,400.00	332,647,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,389,870.00	117,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,389,870.00	117,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	21,501,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	21,501,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,721,982.00	20,800,642.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,721,982.00	3,098,882.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	17,701,760.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	307,441,984.34	406,343,477.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	307,441,984.34	406,343,477.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285,197,433.34	402,810,814.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,355,718.00	232,264,722.00
210101	Үндсэн цалин	143,919,966.00	232,264,722.00
210102	Нэмэгдэл	19,945,471.00	00.00
210104	Урамшуулал	13,490,281.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,875,968.00	31,735,051.00
210201	Тэтгэврийн даатгал	15,368,539.00	21,800,850.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,923,194.00	2,589,690.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,466,011.00	2,012,872.00
210204	Ажигүйдлийн даатгал	353,101.00	484,693.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,765,123.00	4,846,946.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,090,424.00	19,127,668.00
210301	Гэрэл, цахилгаан	1,365,224.00	1,842,908.00
210302	Түлш, халаалт	11,725,200.00	17,284,760.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,100,179.00	20,776,525.00
210401	Бичиг хэрэг	2,157,950.00	2,339,720.00
210402	Тээвэр, шатахуун	13,974,557.00	15,627,590.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	1,108,454.00	1,390,365.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,524,800.00	1,355,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	334,418.00	63,100.00
2105	Нормативт зардал	23,198,278.00	33,467,902.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэргэсэл	17,728,168.00	22,682,012.00
210502	Хоол, хүнс	5,470,110.00	7,290,890.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	3,495,000.00
2106	Эд хөгшил, урсгал засварын зардал	617,500.00	9,405,535.20
210601	Багаж, техник, хэргэсэл	00.00	194,000.00
210604	Урсгал засвар	617,500.00	9,211,535.20
2107	Томилолт, зочны зардал	666,000.00	1,250,000.00
210702	Дотоод албан томилолт	666,000.00	1,250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,734,496.00	13,586,662.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,720,996.00	13,586,662.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	13,500.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,558,870.34	41,196,749.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,541,941.61	5,092,603.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөргөдөл	16,016,928.73	36,104,145.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,244,551.00	3,532,663.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,118,952.00	3,098,882.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,721,982.00	3,098,882.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,396,970.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	125,599.00	376,649.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	125,599.00	376,649.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	57,132.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	57,132.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	15,689,350.27	-10,832,735.44
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	444,575.04	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	444,575.04	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-444,575.04	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	15,244,775.23	-10,832,735.44

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	314,980,252.00	375,066,842.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	314,980,252.00	375,066,842.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	283,868,400.00	332,647,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,389,870.00	117,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,389,870.00	117,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	21,501,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	21,501,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,721,982.00	20,800,642.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,721,982.00	3,098,882.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	17,701,760.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	314,980,252.00	364,706,842.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	314,980,252.00	364,706,842.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	292,735,701.00	361,174,179.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	175,975,400.00	237,244,735.00
210101	Үндсэн цалин	129,328,500.00	174,855,700.00
210102	Нэмэгдэл	32,614,600.00	49,412,135.00
210104	Урамшуулал	14,032,300.00	12,976,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,117,100.00	29,657,100.00
210201	Тэтгэврийн даатгал	14,078,000.00	20,166,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,759,800.00	2,372,600.00
210203	ҮОМШО-ний даатгал	1,407,800.00	1,898,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	352,000.00	474,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,519,500.00	4,745,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,269,224.00	13,944,568.00
210301	Гэрэл, цахилгаан	1,365,224.00	1,842,908.00
210302	Түлш, халаалт	14,904,000.00	12,101,660.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,513,611.00	19,550,774.00
210401	Бичиг хэрэг	1,022,000.00	1,496,200.00
210402	Тээвэр, шатахуун	13,974,557.00	15,197,309.00
210403	Шуудан, холбоо, ингернэгийн төлбөр	1,108,454.00	1,390,365.00
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	1,408,600.00	1,466,900.00
2105	Нормативт зардал	23,000,000.00	32,903,662.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,550,150.00	22,374,712.00
210502	Хоол, хүнс	4,999,850.00	7,239,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,450,000.00	3,289,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,100,000.00	7,179,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,500,000.00	519,200.00
210604	Урсгал засвар	2,600,000.00	6,660,000.00
2107	Томилолт, зочны зардал	666,000.00	1,250,000.00
210702	Дотоод албан томилолт	666,000.00	1,250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,303,400.00	10,684,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,154,900.00	10,684,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148,500.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,790,966.00	8,759,540.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,790,966.00	8,759,540.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,244,551.00	3,532,663.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,118,952.00	3,098,882.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,721,982.00	3,098,882.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,396,970.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	125,599.00	376,649.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	125,599.00	376,649.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	57,132.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	57,132.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	10,360,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	10,360,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	10,360,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	10,360,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	10,360,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-10,360,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	175,490,678.27	127,770,575.89	-100,106,858.41	203,154,395.75
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	175,490,678.27	127,770,575.89	-100,106,858.41	203,154,395.75
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-10,832,735.44	-10,832,735.44
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	175,490,678.27	127,770,575.89	-110,939,593.85	192,321,660.31

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	371,905,000.00	371,416,779.00	488221.00	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	371,905,000.00	371,416,779.00	488221.00	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧЛЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	371,905,000.00	371,416,779.00	488221.00	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	237,256,300.00	237,244,735.00	11565.00	100.0
210101	Үндсэн цалин	174,855,700.00	174,855,700.00	0.00	100.0
210102	Нэмэгдэл	49,423,700.00	49,412,135.00	11565.00	100.0
210104	Урамшуулал	12,976,900.00	12,976,900.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,657,100.00	29,657,100.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	20,166,800.00	20,166,800.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,372,600.00	2,372,600.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,898,100.00	1,898,100.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	474,500.00	474,500.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,745,100.00	4,745,100.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,001,700.00	13,944,568.00	57132.00	99.6
210301	Гэрэл, цахилгаан	1,843,400.00	1,842,908.00	492.00	100.0
210302	Түлц, халаалт	12,158,300.00	12,101,660.00	56640.00	99.5
2104	Хангамж, бараа материалын зардал	19,951,600.00	19,550,774.00	400826.00	98.0
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,496,200.00	3800.00	99.7
210402	Тээвэр, шатахуун	15,035,600.00	15,197,309.00	-161709.00	101.1
210403	Шуудан, холбоо, ингэрнэтийн төлбөр	1,416,000.00	1,390,365.00	25635.00	98.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,466,900.00	533100.00	73.3

**Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2105	Нормативт зардал	32,912,400.00	32,903,662.00	8738.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,212,400.00	22,374,712.00	-162312.00	100.7
210502	Хоол, хүнс	7,250,000.00	7,239,950.00	10050.00	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,450,000.00	3,289,000.00	161000.00	95.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,625,000.00	14,625,000.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,725,000.00	4,725,000.00	0.00	100.0
210602	Тавилга	2,400,000.00	2,400,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	7,500,000.00	7,500,000.00	0.00	100.0
2107	Томилголт, зочны зардал	1,250,000.00	1,250,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилголт	1,250,000.00	1,250,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,567,200.00	10,567,200.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,567,200.00	10,567,200.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11683700.00	11673740.00	9960.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,683,700.00	11,673,740.00	9960.00	99.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	371,905,000.00	371,416,779.00	488221.00	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	332,647,100.00	332,270,451.00	376649.00	99.9
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	332,647,100.00	332,270,451.00	376649.00	99.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,501,700.00	21,444,568.00	57132.00	99.7
132001	Орон нутгийн төсвөөс	21,501,700.00	21,444,568.00	57132.00	99.7
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,756,200.00	17,701,760.00	54440.00	99.7
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,756,200.00	17,701,760.00	54440.00	99.7
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00	0.00	100.0

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл / төгрөгөөр /
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26389870.00	117,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26389870.00	117,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26389870.00	117,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26389870.00	117,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	26389870.00	117,400.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	26389870.00	117,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26389870.00	117,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26389870.00	117,400.00

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

Ж.ӨСӨХБАЯР
Огноо: 2020.02.18

Анхан шатанд хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ
Огноо: 2020.02.18

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ
Огноо: 2020.02.18

